



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/176.

Бат-Өлзий сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Сангийн сайдын "Журам батлах тухай" 2021 оны 06 дугаар сарын 30-ний өдрийн 103 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих сумын 4 дүгээр багийн нутаг Галт, Гуяын нуруу, 2 дугаар багийн нутаг Билүүтийн хөндлөн, 6 дугаар багийн нутаг Улиастайн дэнжид худаг (цооног) гаргах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Э.Дашдулам (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Гишүүд: Ж.Нямтогтох (багийн Засаг дарга)

А.Мандахзул (Иргэний төлөөлөл)

Ж.Ганчулуун (Иргэний төлөөлөл)


Нарийн бичгийн дарга: Э.Бадамханд (Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Э.Дашдулам)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Э.Бадамханд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН



62-301350

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/